Цэргийн Төв Эмнэлгийн Сэргээн засах эмчилгээний тасгаар үйлчлүүлсэн Ковид-19 халдварын дараах хамшинжтэй хүмүүст нойргүйдлийн хүндийн зэргийг судалсан дүн

Г.Индра[1], У.Номин-Эрдэнэ[1], В.Энхтуяа[1]

[1]АШУҮИС, МАУОУС, Зүү төөнө заслын тэнхим
Цахим шуудан: indragonchigsuren@gmail.com, Утас: 99095131

Түлхүүр үг:

Нойргүйдлийн тархалт
Нойргүйдлийн хүндийн зэрэг

Товч утга:

Үндэслэл: Дэлхий даяар Ковид-19 халдвараар өвдсөн хүмүүсийн 10-20%-д ямар нэгэн хам шинж үүссэн бөгөөд тэдгээрийн нэг нь нойргүйдэл юм.[1] Дэлхийн улс орнуудад нойрны эмгэг өргөн тархсан байдаг. АНУ, БНХАУ, Англи улсад Ковид-19 халдварын дараах хам шинжтэй хүмүүст цахим судалгаа хийхэд 78.6% нь нойрны хямралд орсон болохыг тогтоосон байна.[2] Монголчуудын дунд нойргүйдэл 27.9% байсан төдийгүй 42.2% нь нойрны чанар муу болохыг тэмдэглэсэн байна.[3] Гэсэн хэдий ч Ковид-19 халдвараар өвдсөн хүмүүс дунд халдвар авсан давтамжаар нь харьцуулсан судалгаа хийгдээгүй байна. Иймд бид Цэргийн Төв Эмнэлгийн Сэргээн засах эмчилгээний тасгаар үйлчлүүлж буй Ковид-19 халдварын дараах хамшинжтэй үйлчлүүлэгчдийн дунд тохиолдох нойргүйдлийн хүндийн зэргийг үнэлэн, Ковид-19 халдвараар өвдсөн давтамжтай нь харьцуулан судлахыг зорьсон. **Зорилго:** Ковид-19 халдварын дараах хамшинжтэй хүмүүст нойргүйдлийн хүндийн зэргийг үнэлэн, харьцуулан судлах. **Арга, аргачлал:** Бид судалгааг эмнэлэгт суурилсан нэг агшингийн судалгааны загвар ашиглан Цэргийн Төв Эмнэлгийн Сэргээн засах эмчилгээний тасгаар 2022 оны 05 дугаар сараас 09 дүгээр сарын хооронд үйлчлүүлсэн Ковид-19 халдварын дараах хам шинжтэй 100 үйлчлүүлэгчийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч Морин нарын 1993 онд боловсруулсан Insomnia Severity Index (ISI) нойргүйдлийн хүндийн зэргийн үнэлэх олон улсын стандарт асуумжийг ашиглан судалгааны мэдээллийг цуглуулав. Судалгааны мэдээллийг Дескриптив статистик, one way Anowa тестийг ашиглан Ковид-19 халдвараар өвдсөн давтамжийг нойргүйдлийн хүндийн зэрэгтэй харьцуулан судлав. **Үр дүн:** Бидний судалгаанд хамрагдагсдын 61% нь эмэгтэй, дундаж нас 50.0±2.8 жил байв. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдэд нойргүйдэл өндөр хувьтай байсан ба 40%-д нь нойргүйдлийн дунд зэрэг, 55%-д нь эмнэлзүйн хүнд зэргийн нойргүйдэл илэрсэн. Ковид-19 халдвараар судалгаанд оролцогчдын 53.3% 1 удаа, 30% нь 2 удаа, 16.6% нь 3 удаа өвдсөн байсан бөгөөд олон удаа өвдөх нь нойргүйдлийн хүндийн зэргийг статистик ач холбогдолтойгоор нэмэгдүүлж байсан ($p<0.001$). **Дүгнэлт:** 1. Бидний судалгааны үр дүнд судалгаанд оролцогчдын 95% нь нойргүйдлийн дунд болон хүнд зэргийн түвшинтэй байв. 2. Нойргүйдлийн хүндийн зэрэг нь Ковид-19 халдвараар өвдсөн давтамжаас хамааран ялгаатай байв. Цаашид ковид-19 халдварын дараах нойргүйдлийн хамшинжтэй хүмүүсийг хамруулсан эмнэлзүйн дагаж судалсан судалгааг хийх шаардлагатай байна.

Үндэслэл: Судлаачдын тодорхойлсноор бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх шалтгааны улмаас нойрсох болон унтаж амрах боломжгүй болохыг нойргүйдэл гэнэ.[4] ДЭМБ-аас 14 улс орны нойргүйдэлд хийсэн судалгаанд үндсэн шатны эмнэлгийн байгууллагад хандан эмчилгээ хийлгэж байгаа өвчтний 27% нь нойрны ямар нэгэн асуудалтай гэсэн бол АНУ-д 50%, Англид 10-14%, Францад 30%, БНХАУ-д 30% тус тус их байна.[5] 2019 онд БНХАУ-д хүн амын дунд хийгдсэн нойрны чанарын судалгаанд нийт оролцогчдын 1/3-д нь нойрсолтын чанар хангалтгүй гэсэн үр дүнд гарч, урт хугацаагаар нойргүйдсэнээс мэдрэлийн системийн, физиологийн болон дархлааны үйл ажиллагаанд илт сөрөг нөлөө үзүүлж, чихрийн шижин, зүрх цусан судасны өвчин, цусны даралт ихсэлт, уур бухимдал, таргалалт зэрэг өвчнүүдийг үүсгэж гэр бүл, нийгмийн хэвийн үйл ажиллагаанд шууд нөлөөлж байна гэж дүгнэжээ.[6] 2020

оны байдлаар А.Энхнаран нарын Монгол орон даяар 964 хүнийг хамруулсан судалгаагаар Монголчуудын дунд органик бус нойргүйдэл нь 27.9 хувь тархсан төдийгүй 42.2 хувь нь нойрны чанар муу байна гэжээ.[7]

Коронавируст халдварын дараах хамшинж нь олон эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны өөрчлөлтөөр илэрдэг эмгэг бөгөөд үүний дотор нойрны өөрчлөлтүүд, ялангуяа нойргүйдэл нийт үйлчлүүлэгчдийн 18-30%-д илэрч, ихэнх үйлчлүүлэгчид 1 жилээс дээш хугацаагаар үргэлжилдэг байна.[8] Кливленд Клиникийн судлаачдын үзэж байгаагаар урт (хугацааны) Ковид-19 халдвартай өвчтөнүүдийн 41% нь нойрны өөрчлөлт оношлогдсон бол 59427 анагаахын оюутныг хамруулсан 109 судалгааны үр дүнд хийсэн мета анализ нь судалгаанд хамрагдагсдын 55.6% нь нойрны чанар муу байна гэжээ[9-10]. 2020 онд Ц.Басбиш нарын судалгаанд Ковид-19 халдварын үед тэргүүн эгнээнд ажиллаж буй 1085 эрүүл мэндийн ажилчдын нойрны чанарыг үнэлэхэд 67% нь хангалтгүй байгаа нь тодорхойлсон байна.[11]

Ковид-19 халдвар тархахаас өмнө нийт хүн амын 17 хувь нь нойрны асуудалтай байсан. Харин цар тахал, хөл хорионы улмаас дэлхий даяар нойрны ямар нэг асуудалтай хүмүүсийн эзлэх хувь 38 болж өссөн баримт байна[12]. Өөрөөр хэлбэл гурван хүн тутмын нэг нь нойргүйдэлтэй байгаа судалгаа байна. Цар тахал, хөл хориотой холбоотой сэтгэл зүйн асуудалд өртөж, нойрны асуудал үүсэх, тэр дундаа нойрны үргэлжлэх хугацаа багасах, нойр ханахгүй байх, нойр хүрэхгүй байх, шөнөдөө хэд хэдэн удаа сэрж нойргүйдэх эмнэлзүйн шинж тэмдэг илэрч байна[13]. Энэ нь эргээд дархлаа тогтолцоонд нөлөөлж сэтгэлзүй, биемахбодын талаас олон сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Бодисын солилцооны үйл ажиллагаа хямрах, ой тогтоолт муудах, шийдвэр гаргах чадвар болон танин мэдэхүйн үйл ажиллагаа буурах шинж тэмдэгүүд илэрнэ. Иймд бид Цэргийн төв эмнэлгийн сэргээн засах эмчилгээний тасгаар үйлчлүүлж буй ковидын халдварын дараах хамшинжтэй өвчтөнүүдийн нойргүйдлийн төвшин болон нойрны чанарыг үнэлэн, эмнэлзүйн туршилт судалгааг явуулах боломжийг эрэлхийллээ.

Зорилго: Ковид-19 халдварын дараах хамшинжтэй хүмүүст нойргүйдлийн хүндийн зэргийг үнэлэх, харьцуулан судлах

Зорилт:

1. Нойргүйдлийн ОУ-ийн хүндийн зэргийн (ISI) асуумжаар Ковид-19 халдварын дараах хамшинжтэй хүмүүст нойргүйдлийн хүндийн зэргийг тодорхойлох.
2. Ковид-19 халдвараар өвдсөн давтамжаар нь нойргүйдлийн хүндийн зэргийг харьцуулан судлах.

Арга, аргачлал: Бид судалгааг эмнэлэгт суурилсан нэг агшингийн судалгааны загвар ашиглан Цэргийн Төв Эмнэлэгийн Сэргээн засах эмчилгээний тасгаар 2022 оны 05 дугаар сараас 09 дүгээр сарын хооронд үйлчлүүлсэн Ковид-19 халдварын дараах хам шинжтэй 100 үйлчлүүлэгчийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгаанд хамруулав. АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2022 оны 05 сарын 20-ны өдрийн №2022/3-05 тоот хурлаар судалгааны арга аргачлалыг хэлэлцүүлж, судалгааг хийх ёс зүйн зөвшөөрөл авсан. Morin.M (1993) нарын боловсруулсан Insomnia Severity Index (ISI) нойргүйдлийн хүндийн зэргийн үнэлэх олон улсын стандарт асуумжийг ашиглан судалгааны мэдээллийг цуглуулав. ОУ-ын нойргүйдлийн хүндийн зэргийн 7 асуулт бүхий асуумжаар судалгааг авч нойргүйдлийг эмнэлзүйн хөнгөн, дунд, хүнд зэргээр тодорхойлов. 0-7 оноотой бол нойргүйдэлгүй, 8-14 оноотой бол босго доогуур нойргүйдэл, 15-21 оноотой бол нойргүйдлийн дунд зэрэг, 22-28 оноотой бол нойргүйдлийн хүнд зэрэгтэй гэж тус тус үнэлсэн. Судалгааны статистик боловсруулалтыг SPSS-22 программыг ашиглан, судалгааны хүн ам зүйн мэдээлэл болон хувьсагчдын түвшинг тодорхойлохдоо Дескриптив статистик, Ковид-19 халдвараар өвдсөн давтамжийг нойргүйдлийн хүндийн зэрэгтэй харьцуулахдаа One-way Anova тестийг тус тус ашиглав. Статистик ялгааг $p<0.05$ утгатай байгаа тохиолдолд статистик үнэн магадлалтай гэж тооцсон.

Үр дүн: Судалгаанд оролцогчдын дундаж нас нь 50.0±2.82 жил, хүйсийн хувьд 61.0% (n=61) нь эмэгтэй байв. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Хүн ам зүйн мэдээлэл

Үзүүлэлт	Бодит тоо (n)	Эзлэх хувь (%)
Нас (жил)(=50.82, SD=2.05, Range= 31-80)		
Эрэгтэй	39	39
Эмэгтэй	61	61
Ковидоор өвдсөн тоо		
1 удаа	53	53.3
2 удаа	30	30
3 удаа	17	16.6
Нойргүйдлийн 4 түвшин		
0-7 оноо	0	0
8-14 оноо	5	5
15-21 оноо	40	40
22-28 оноо	55	55

Нойргүйдлийн хүндийн зэргийг судлахад судалгаанд оролцогчдын 40%-д нь дунд зэргийн, 55%-д нь эмнэлзүйн хүнд зэргийн нойргүйдэл илэрч байгаа нь тодорхойлогдсон.



Зураг 1. Ковид-19 халдвартай үйлчлүүлэгсдийн нойргүйдлийн хүндийн зэрэг (%)

Судалгаанд оролцогчдын 53.3% нь ковидоор 1 удаа, 30% нь 2 удаа, 16.6% нь 3 удаа ковидоор өвдсөн байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Нойргүйдлийн хүндийн зэргийг тодорхойлсон дүн

Нойргүйдлийн хүндийн зэргийн асуумж	1 удаа	2 удаа	3 удаа
	53	30	17
Нойрсоход хүндрэлтэй байх	2.72	2.74	3.16
Унтахад хүндрэлтэй байх	2.49	2.57	3.17
Хэт эрт босох асуудалтай	2.51	2.49	2.83
Та одооны нойрны хэв маягтаа хэр сэтгэл хангалуун байгаа вэ?	2.86	2.87	2.92
Таны нойрны асуудал таны амьдралын чанарыг муутгаж буйгаараа бусдад хэр их анхаарал хандуулдаг гэж та бодож байна вэ?	2.38	2.47	2.45
Та одоогийн нойрны асуудалдаа хэр санаа зовсон/зовдог вэ?	2.37	2.54	2.61
Таны нойрны асуудал таны өдөр тутмын үйл ажиллагаанд (жишээ нь, өдрийн цагаар) хэр зэрэг саад учруулдаг гэж та үзэж байна вэ?	2.27	2.42	3.19

Ковид-19 халдвараар хэдэн удаа өвдсөнөөс хамаарааД нойрны хүндийн зэрэгтэй харьцуулан үзэхэд 1 болон 2 удаа өвдсөн хүмүүс хүндийн зэрэг бага буюу дундаж оноо бага байгаа бол харин 3 удаа өвдсөн хүмүүсийн дундаж оноо өндөр байгаа нь ажиглагдлаа.

Хүснэгт 3. Ковид-19 халдвараар өвдсөн давтамжийг нойргүйдлийн хүндийн зэргээр харьцуулан судалсан үр дүн

Ковид-19 халдварын өвдсөн давтамжийг нойргүйдлийн хүндийн зэрэг харьцуулах		Sum of Squares	Df	Mean Square	F	Sig.
Ковид-19 халдвараар хэдэн удаа өвдсөн бэ	Between Groups	.116	1	.116	5.474	.000
	Within Groups	24.074	98	.246		
	Total	24.190	99			
Нойргүйдлын хүндийн зэрэг	Between Groups	.812	1	.812	2.418	.012
	Within Groups	32.898	98	.336		
	Total	33.710	99			

Анова шинжилгээнээс үзэхэд Sig 0.05-с бага бөгөөд F утга нь 5.474 байгаа нь хамааралтай гарчээ. Энэ нь ялгаатай байдлыг үнэлсэн бөгөөд ковид-19 халдвараар хэр олон удаа өвдсөн байгаа нь тухайн нойргүйдлын хүндийн зэрэгтэй шууд хамааралтай байгаа нь тус тус тодорхойлогдсон.

Хэлцэмж: Цэргийн төв эмнэлгийн сэргээн засах тасгаар үйлчлүүллэгчдийг хамруулан судалсан бидний судалгааны үр дүнд нойргүйдлийн түвшин нийт 95 хувьд нь нойргүйдлийн дунд болон хүнд зэрэг илэрсэн нь Ковид-19-ээр халдварлах нь урт ковид буюу халдварын дараах хамшинжийн үед нойргүйдэлд өртөх өндөр эрсдэлтэйг харуулж байна. Бидний судалгааны үр дүн нь дараах хэд хэдэн судалгааны ажлуудын үр дүнтэй ижил төстэй байна. Үүнд Morin.M нар (2021) нойргүйдлийн тархалт тахал өвчний өмнөх үеийнхтэй харьцуулахад 25% -иар өссөн гэж мэдээлсэн бол өөр нэг судалгааны мэдээллээс үзэхэд нойргүйдэх, унтахад хүндрэлтэй өдрүүдийг мэдээлсэн хүмүүсийн тоо харьцуулахад бараг хоёр дахин нэмэгдсэн байна.[13] Нойргүйдлийн шинж тэмдгийг үнэлэхийн тулд нойргүйдлийн хүндийн индексийг (ISI) ашигласан судалгааны сүүлийн үеийн мета-анализ нь мөн Ковид-19 цар тахал нь нойргүйдлийн шинж тэмдгүүдийн өндөр түвшинтэй холбоотой боловч дунд зэргийн буюу хүнд хэлбэрийн нойргүйдлийн шинж тэмдэг биш болохыг тогтоожээ.[14]

Мөн бидний судалгааны хоёрдох зорилтын хүрээнд нойргүйдлийн хүндийн зэрэг нь Ковид-19 халдвараар өвдсөн давтамжаас хамааран ялгаатай байв. Ковид-19 халдварт өртсөн тоо нь нойргүйдлийн хамшинжийг үүсгэх эрсдэлт хүчин зүйл болж байна. Энэ нь Chen нарын судалгааны үр дүнтэй ижил, төстэй буюу Ковид-19 халдварт өртөх давтамж нь нойргүйдлийг үүсгэх эрсдэлт хүчин зүйл гэж үзсэн нь дээрх дүгнэлттэй дүйцэж байна[15]. Цаашид Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, халдварт өртсөн хүмүүст нойргүйдлийг тусгайлан үнэлэн цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь чухал ач холбогдолтой юм.

Дүгнэлт:

1. Бидний судалгааны үр дүнд судалгаанд оролцогчдын 95% нь нойргүйдлийн дунд болон хүнд зэргийн түвшинтэй байв.
2. Нойргүйдлийн хүндийн зэрэг нь Ковид-19 халдвараар өвдсөн давтамжаас хамааран ялгаатай байв. Цаашид ковид-19 халдварын дараах нойргүйдлийн хамшинжтэй хүмүүсийг хамруулсан эмнэлзүйн дагаж судалсан судалгааг хийх шаардлагатай байна.

Талархал: Уг судалгааг явуулахад дэмжсэн ЦТЭ-ийн дарга-ерөнхий эмч хурандаа Б.Энх-Од, ЦТЭ-ийн СЗЭТасгийн эрхлэгч дэд хурандаа В.Ундрам болон нийт судалгаанд оролцогсоддоо талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Cox R.C., Olatunji B.O. Sleep in a pandemic: implications of COVID-19 for sleep through the lens of the 3P model of insomnia. Am Psychol. 2021 Jun 17 doi: 10.1037/amp0000850. Online ahead of print. PMID: 34138586. [PMC free article] [PubMed] [CrossRef] [Google Scholar] [Ref list]*
2. *Sleep disturbance in post COVID-19 conditions: Prevalence and quality of life Rimawati Tedjasukmana, 1 Astri Budikayanti,corresponding author 2, 3, * Wardah Rahmatul Islamiyah, 4, 5 Anastasia Melissa Ayu Larasati Witjaksono, 2, 3 and Manfaluthy Hakim 2, 3 2023 Jan 9. doi: 10.3389/fneur.2022.1095606*
3. *Enkhnaran.A Tumurbaatar.G et al, Nonorganic sleep disorders and sleep quality among the general population of Mongolia, Proceedings of Mongolian Academy of Sciencesm Vol. 63 No 01 (245) 2023*
4. *J. Guo, L.P. Wang, C.Z. Liu, et al. Efficacy of acupuncture for primary insomnia: a randomized controlled clinical trial Evid Based Complement Altern Med, 2013 (2013), p. 163850*
5. *Insomnia Management: A Review and Update David P Shaha PMID: 37549414 PMCID: PMC10416725 DOI: 10.12788/jfp.0620*
6. *The prevalence and associated factors of sleep deprivation among healthy college students in China: a cross-sectional survey Congcong Guo,#1 Songzhe Piao,#2 Chenyu Wang,1 Lili Yu,3 Kejun Wang,1 Qian Qu,1 Cuiting Zhang,1 and Xiaofei Yucorresponding author1 2023 Sep 18. doi: 10.7717/peerj.16009*
7. *Enkhnaran Tumurbaatar et al, Nonorganic sleep disorders and sleep quality among the general population of Mongolia, Proceedings of Mongolian Academy of Sciencesm Vol. 63 No 01 (245) 2023*
8. *Post-Acute Coronavirus (COVID-19) Syndrome Venu Chippa; Abdul Aleem; Fatima Anjum.* February 3, 2023.
9. *https://covid19.nih.gov/news-and-stories/understanding-sleep-problems-long-covid*
10. *Mohammed A. Binjabr et.al. The Worldwide Prevalence of Sleep Problems Among Medical Students by Problem, Country, and COVID-19 Status: a Systematic Review, Meta-analysis, and Meta-regression of 109 Studies Involving 59427 Participants. Current Sleep Medicine Reports Jun 2023, pages 161–179`*
11. *Frontline Mongolian Healthcare Professionals and Adverse Mental Health Conditions During the Peak of COVID-19 Pandemic. Basbish Tsogbadrakh1 Enkhjargal Yanjmaa1 Oyungoo Badamdorj1* Dorjderem Choijiljav1 Enkhjargal Gendenjamts2 Oyunerdene Ayush3 Odonjil Pojin1 Battogtokh Davaakhuu1 Tuya Sukhbat1 Baigalmaa Dovdon1 Oyunsuren Davaasuren4 Azadeh Stark5,6,7 11 March 2022Sec. Health Psychology Volume 13 - 2022 | https://doi.org/10.3389/fpsyg.2022.800809*
12. *The Prevalence of Psychological Distress and Its Relationship to Sleep Quality in Saudi Arabia's General Population During the COVID-19 Pandemic Maha M. AlRasheed,corresponding author 1, 2, * Sinaa Al-Aqeel, 1 Afnan M. Alkadir, 1 Khulood Bin Shuqiran, 1 Fowad Khurshid, 1 Noura M. AlRasheed, 3 Roua M. Al-kufeidy, 4 Omar A. Alhaj, 5 Haitham Jahrami, 6, 7 and Ahmed S. BaHammam 8, 9 2022 Feb 3. doi: 10.3389/fpsyt.2021.809040*
13. *Hisler G.C., Twenge J.M. Sleep characteristics of U.S. adults before and during the COVID-19 pandemic. Soc Sci Med. 2021:276. doi: 10.1016/j.socscimed.2021.113849. [PMC free article] [PubMed] [CrossRef] [Google Scholar] [Ref list].*
14. *AlRasheed M.M., Fekih-Romdhane F., Jahrami H., et al. The prevalence and severity of insomnia symptoms during COVID-19: a global systematic review and individual participant data meta-analysis. Sleep Med. 2022;100:7–23. doi: 10.1016/j.sleep.2022.06.020. [PMC free article] [PubMed] [CrossRef] [Google Scholar] [Ref list]*
15. *Si-Jing Chen et al, The association of insomnia with long COVID: An international collaborative study (ICOSS-II), Sleep Medicine Volume 112, December 2023, Pages 216-222*

Insomnia severity was studied in people with post-Covid-19 syndrome who attended the Rehabilitation Department of the Military Central Hospital

Indra G[1], Nomin-Erdene U[1], Enkhtuya V[1]

[1]Department of Acupuncture and Moxibustion, ISMM, MNUMS
E-mail: indragonchigsuren@gmail.com, Tel: +976-99095131

Background: Worldwide, 10-20% of people infected with Covid-19 develop some kind of syndrome, one of which is insomnia.1 Sleep disorders are widespread in many countries around the world. An online survey of people with post-Covid-19 syndrome in several countries found that 78.6% suffered from sleep disturbances.2 In a 2020 study by Enhtsetseg and Timurbaatar, which included 964 people in Mongolia, 27.9% of Mongolians had insomnia, and 42.2% had poor sleep quality. .3 However, no studies have been conducted comparing the frequency of infection among people with Covid-19. Therefore, we aimed to evaluate the severity of insomnia among clients with post-Covid-19 syndrome who are serving in the Rehabilitation Department of the Military Central Hospital and compare it with the frequency of covid-19 infection. In the future, the results of this study are important for optimally selecting and implementing treatment options for the treatment of epidemic-induced insomnia.
Aim: To evaluate and compare the severity of insomnia in people with post-Covid-19 syndrome.
Materials and Methods: We used a hospital-based single-point research design to randomly select 100 patients with post-Covid-19 syndrome who attended the Rehabilitation Department of the Military Central Hospital between May and September 2022. Insomnia was developed in 1993 by Morin et al. Study data were collected using the Severity Index (ISI), a standardized international questionnaire for assessing the severity of insomnia. Data were analyzed using descriptive statistics and the one-way Anowa test to compare the frequency of covid-19 infection with the severity of insomnia.
Results: 61% of the participants in our study were women, and the average age was 50.0±2.8 years. A high rate of insomnia was present in the clients studied, with 40% having moderate insomnia and 55% having clinically severe insomnia. 53.3% of study participants had 1, 30% 2, and 16.6% 3 illnesses due to Covid-19 infection, and multiple illnesses increased the severity of insomnia with statistical significance ($p<0.001$).
Conclusion: In our study, 95% of subjects with post-Covid-19 syndrome had clinically moderate to severe insomnia, and comorbidity with covid-19 increased the severity of insomnia. Further clinical follow-up studies involving people with post-Covid-19 insomnia syndrome are needed.

Keywords: Insomnia prevalence, Insomnia severity